

Golomt Capital®

# Хөрөнгийн зах зээлийн ТОЙМ

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.07.18

Олон улсын  
хөрөнгийн зах зээл


Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ОНЦЛОХ ИНДЕКСҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ

Дэлхийн томоохон индексүүдийг бүс нутгаар нь ангилан 7 хоног, сар, жилийн ханшийн өөрчлөлтүүдийг үзүүлэв. Үүнд АНУ-ын Dow Jones, S&P 500, Nasdaq, Германы Dax, Английн FTSE 100, БНХАУ-ын CSI 300, Хонг-Конгийн Hang Seng, Японы Nikkei 225 индексүүд багтана.

Америкийн индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
Dow Jones	\$31,288.26	\$31,338.15	-0.16%	\$29,888.00	4.69%	\$34,687.85	-9.80%
S&P 500	\$3,863.16	\$3,899.00	-0.92%	\$3,674.00	5.15%	\$4,327.16	-10.72%
Nasdaq	\$11,452.00	\$11,635.31	-1.58%	\$10,798.35	6.05%	\$14,427.00	-20.62%
Европийн индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
Dax	€ 12,864.00	€ 13,015.23	-1.16%	€ 13,126.00	-2.00%	€ 15,540.31	-17.22%
FTSE 100	£7,159.00	£7,122.00	0.52%	£7,202.00	-0.60%	£7,012.00	2.10%
Азийн индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
CSI 300	¥4,248.00	¥4,428.00	-4.07%	¥4,309.00	-1.42%	¥5,094.00	-16.61%
Hang Seng	HKD 20,297.00	HKD 21,725.00	-6.57%	HKD 21,075.00	-3.69%	HKD 28,004.00	-27.52%
Nikkei 225	JPY 26,788.00	JPY 26,517.00	1.02%	JPY 25,963.00	3.18%	JPY 28,003.00	-4.34%

Индексийн өөрчлөлт



■ 7 хоногийн өөрчлөлт ■ Сарын өөрчлөлт ■ Жилийн өөрчлөлт

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ


### АНУ-ЫН ИНФЛЯЦЫН ТҮВШИН 9.1 ХУВЬ ХҮРЛЭЭ

Өнгөрсөн долоо хоногт АНУ-ын 6-р сарын хэрэглээний үнийн индекс зарлагдаж, 9.1 хувьд хүрсэн үзүүлэлттэй байлаа. Шинжээчид инфляцыг 8.8 хувьтай байна гэж таамаглаж байснаас өндөр үзүүлэлттэй байгаа нь олон нийтийн санааг зовоож байна.

АНУ-д одоогийн инфляцын түвшин дундаж цалингаас хурдацтай өсөж байгаа нь өрх гэрийн худалдан авалт хийх чадварыг бууруулж байна.

Хоол хүнс, шатахуун, түрээс, бордоо зэргээс гадна даатгал, хувцас, тавилга, шинэ болон хуучин автомашины үнэ өссөн үзүүлэлттэй байна. Ялангуяа, ОХУ болон Украины дайнаас үүдэн нийлүүлэлтэд саад тулгарч, эрчим хүчний үнэ өссөн нь инфляцыг өдөөх томоохон шалтгаан болсон.

АНУ болон Европ бүс нутгуудын төв банк аль болох инфляцыг хяналтад оруулах зорилготойгоор ажиллаж байна. Тухайлбал, АНУ өнгөрсөн сард бодлогын хүүг 75 нэгжээр өсгөсөн. Энэ сарын бодлогын хүүн шийдвэрийг дараа долоо хоногт зарлана.



TRADINGECONOMICS.COM | U.S. BUREAU OF LABOR STATISTICS

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### ЭНЭ ДОЛОО ХОНОГТ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР АЖИГЛАХ ТАВАН ЗҮЙЛС

#### 1. Компаниудын санхүүгийн тайлан

Энэ долоо хоногт зарим томоохон компаниуд өөрсдийн 2-р улирлын тайланг зарлах болно.

Даваа гарагт Bank of America, Goldman Sachs Group зэрэг томоохон санхүүгийн байгууллагууд, мягмар гарагт Johnson & Johnson, Novartis AG ADR, лхагва гарагт Abbott Labs, пүрэв гарагт U.S. Roche Holding AG, AT&T, харин баасан гарагт Verizon Communications тайлангаа зарлах болно.

#### 2. Техник технологийн компаниудын тайлан

Энэ жил техник технологийн компаниудын хувьцааны ханш нэлээд уналттай байсан ба эдүгээ өрнөж буй үйл явц тухайн компаниудад хэрхэн нөлөөлснийг 2-р улирлын тайлангаас харж болно.

Энэ долоо хоногт Netflix, Snap, Tesla, ASML Holdings, Twitter зэрэг томоохон компаниуд тайлангаа зарлах болно.

#### 3. Европын төв банкны хуралдаан

Европын төв банк энэ пүрэв гарагт хуралдан, бодлогын хүүг өсгөх талаар хэлэлцэнэ.

Энэ хуралдаан болохоос өмнө Евро бүс нутгийн хэрэглээний үнийн индекс зарлагдах нь төв банкны шийдвэрт бодлогын хүүг хэр их хэмжээгээр өсгөх тал дээр баримжаа үзүүлнэ.

#### 4. Английн эдийн засгийн үзүүлэлтүүд

Англи улсын эдийн засгийн үзүүлэлтүүд энэ долоо хоногийн лхагва гарагт зарлагдана. Хэрэглээний үнийн индекс, ажил эрхлэлтийн тоон үзүүлэлтүүд зарлагдах ба ерөнхий сайд Boris Johnson-ийг орлох хүнийг томилох талаар мэтгэлцээн явагдах болно.

#### 5. Газрын тос

Crude Oil WTI Фьючерс өнгөрсөн таван долоо хоногт ойролцоогоор 20 хувиар унасан. Газрын тосны ханш үргэлжлэн унах нь инфляцын дарамтыг багасгах ч эдийн засгийн удаашралын шинж тэмдэг болж өгнө.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан

E EARNINGS WHISPERS		The Most Anticipated Earnings Releases									
		for the month beginning July 11, 2022									
		(only showing confirmed release dates)									
		Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
11		12		13		14		15			
18		19		20		21		22			
25		26		27		28		29			
01		02		03		04		05			
08		09		10		11		12			

## Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases									
		for the week beginning July 18, 2022									
		Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
		Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.